



МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛВОО

2020 ОНЫ 10.30-31



ТАЕКВОНДОГИЙН
УЛСЫН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

“ОЛИМП” ХАНДГАЙТ
ЦОГЦОЛБОРТ

2020

ЗАЛУУЧУУД
НАСАНД ХҮРЭГЧИД
МАСТЕР АНГИЛАЛ
ЗХЗ БАГИЙН ТУЛААН





“МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛБОО” ГҮТББ-ЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Д.ЭНХБАТ

**“МОНГОЛЫН ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН ЗАЛУУЧУУД, НАСАНД ХҮРЭГЧ,
МАСТЕР АНГИЛЛЫН ХХVIII УДААГИЙН УАШТ”-ИЙ ЗААВАР**

ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:

- Таеквондогийн спортыг сурталчилах,
- Монгол улсад олимпийн таеквондогийн спортыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудад таеквондогийн спортоор хичээллэх ач тусыг таниулах.
- Баг тамирчдын ур чадварыг дээшлүүлж, харилцан туршлага солилцох.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Зохион байгуулагч	Монголын Таеквондогийн Холбоо
Холбоо барих	9696-2288, 7015-5500, 8010-0471
E-mail	info@mongoliatekwondo.mn
Facebook хуудас	www.facebook.com/mongol.tkd/
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 8-р хороо, Спортын төв Ордон

ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:

Өдөр	Хөтөлбөр	Байршил
2020.10.22	• Мэдүүлэг хүлээж авна	info@mongoliatekwondo.mn
2020.10.29	• Тамирчдын жин үзнэ	ҮШБ-ийн заал
2020.10.29	• Тэмцээний техникийн зөвлөгөөн	Хандгайт Их тамир олимп спорт цогцолбор
2020.10.30,31	• Тэмцээн	Хандгайт Олимп спорт цогцолбор

- Заасан хугацаа хэтэрсэн багийн мэдүүлгийг хүлээн авахгүй!

ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР:

1. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Оролцогч тамирчин нь Монголын таеквондогийн холбоо болон Күккивоны ямар нэг зэрэг, дантай байна, зөвхөн тэр бүсээ тоглолтонд бүсэлнэ.
- Тэмцээнд оролцогч тамирчин бүр таеквондогийн ёс, дэг журмыг чанд баримтлан, хувийн ариун цэврийг дээд зэргээр хангасан байх шаардлагатай. Үүнд: гар, хөлийн хумсыг засаж, элдэв бөгж, хүзүүний зүүлт зэргийг хэрэглэхгүй байх
- Тамирчдаа эрүүл мэндийн үзлэгт заавал оруулж мэдүүлэгтээ хавсаргасан байх.
- Тэмцээнд оролцогч багууд тамирчдынхаа байр, хоолыг өөрсдөө хариуцна.
- *Тамирчдын жинг олон кг-р хасахгүй байхыг нийт багш, дасгалжуулагч нарт онцгой анхааруулж байна*
- Тулаан цахим хугун дээр явагдана.
- Шүдний хамгаалалтын хувьд өнгөгүй тунгалаг эсвэл цагаан өнгөтэйгээс бусад өнгөтэй шүдний хамгаалалт зүүхийг хориглоно.
 - **ЖИЧ:** УОК, ЭМЯ бусад байгууллагын цар тахлын үед гаргасан заавар, зөвлөмжийн дагуу маск, бээлий, гар ариутгагчтай зохион байгуулагдана.

2. ТУЛААН /ЖИНГИЙН ДАРААЛАЛ/

2.1 ГАНЦААРЧИЛСАН ТУЛААН

Залуучууд /15-17 нас/:

Эр		Эм	
- 45 кг	45 кг хүртэлх	- 42 кг	42 кг хүртэлх
- 48 кг	45 кг жингээс 48 кг жингийн хооронд	- 44 кг	42 кг жингээс 44 кг жингийн хооронд
- 51 кг	48 кг жингээс 51 кг жингийн хооронд	- 46 кг	44 кг жингээс 46 кг жингийн хооронд
- 55 кг	51 кг жингээс 55 кг жингийн хооронд	- 49 кг	46 кг жингээс 49 кг жингийн хооронд
- 59 кг	55 кг жингээс 59 кг жингийн хооронд	- 52 кг	49 кг жингээс 52 кг жингийн хооронд
- 63 кг	59 кг жингээс 63 кг жингийн хооронд	- 55 кг	52 кг жингээс 55 кг жингийн хооронд
- 68 кг	63 кг жингээс 68 кг жингийн хооронд	- 59 кг	55 кг жингээс 59 кг жингийн хооронд
- 73 кг	68 кг жингээс 73 кг жингийн хооронд	- 63 кг	59 кг жингээс 63 кг жингийн хооронд
- 78 кг	73 кг жингээс 78 кг жингийн хооронд	- 68 кг	63 кг жингээс 68 кг жингийн хооронд
+ 78 кг	78 кг жингээс дээш жинтэй тамирчид	+ 68 кг	68 кг жингээс дээш жинтэй тамирчид

Насанд хүрэгч /18-31/:

Эр		Эм	
- 54 кг	54 кг хүртэлх	- 46 кг	46 кг хүртэлх
- 58 кг	54 кг жингээс 58 кг жингийн хооронд	- 49 кг	46 кг жингээс 49 кг жингийн хооронд
- 63 кг	58 кг жингээс 63 кг жингийн хооронд	- 53 кг	49 кг жингээс 53 кг жингийн хооронд
- 68 кг	63 кг жингээс 68 кг жингийн хооронд	- 57 кг	53 кг жингээс 57 кг жингийн хооронд
- 74 кг	68 кг жингээс 74 кг жингийн хооронд	- 62 кг	57 кг жингээс 62 кг жингийн хооронд
- 80 кг	74 кг жингээс 80 кг жингийн хооронд	- 67 кг	62 кг жингээс 67 кг жингийн хооронд
- 87 кг	80 кг жингээс 87 кг жингийн хооронд	- 73 кг	67 кг жингээс 73 кг жингийн хооронд
+ 87 кг	87 кг жингээс дээш жинтэй тамирчид	+ 73 кг	73 кг жингээс дээш жинтэй тамирчид

Мастер /32-оос дээш/:

Эр		Эм	
- 58кг	58кг хүртэлх	- 49кг	49кг хүртэлх
- 68кг	58кг жингээс 68кг жингийн хооронд	- 57кг	49кг жингээс 57кг жингийн хооронд
- 80кг	68кг жингээс 80кг жингийн хооронд	- 67кг	57кг жингээс 67кг жингийн хооронд
+ 80кг	80кг жингээс дээш жинтэй тамирчид	+ 67кг	67кг жингээс дээш жинтэй тамирчид

- ❖ Нэг жинд нэг байгууллагаас оролцох тамирчны тоог хязгаарлахгүй.
- ❖ Жин тус бүрт заасан жиндээ багтаж орох хэрэгтэй ба заасан жингээс 100гр илүү жинтэй байх тохиолдолд жиндээ орж чадахгүй хасагдана. Жиндээ орж чадаагүй тамирчин дээд жиндээ орж болохгүй буюу зөвхөн мэдүүлэгт өгсөн жиндээ орох шаардлагатай.

2.2 БАГИЙН ТУЛААН:

Нийт 4 тамирчинтай багийн тамирчдын нийлбэр жин 253 кг-аас хэтрэхгүй байх ёстой.

Залуучууд:

Эр	
-55 кг	55 кг хүртэлх
-60 кг	55 кг жингээс 60 кг жингийн хооронд
-65 кг	60 кг жингээс 65 кг жингийн хооронд
-73 кг	65 кг жингээс 73 кг жингийн хооронд

Эмэгтэй багийн нийлбэр жин 230 кг-аас хэтрэхгүй байх ёстой.

Эм	
-50 кг	50кг хүртэлх
- 55 кг	50 кг жингээс 55 кг жингийн хооронд
-60 кг	55 кг жингээс 60 кг жингийн хооронд
-65 кг	60 кг жингээс 65 кг жингийн хооронд

Нийт 4 тамирчинтай багийн тамирчдын нийлбэр жин 269кг-аас хэтрэхгүй байх ёстой.

Насанд хүрэгч:

Эр	
- 58 кг	58кг хүртэлх
- 63 кг	58 кг жингээс 63 кг жингийн хооронд
- 68 кг	63 кг жингээс 68 кг жингийн хооронд
-80 кг	68 кг жингээс 80 кг жингийн хооронд

Эмэгтэй багийн нийлбэр жин 231 кг-аас хэтрэхгүй байх ёстой.

Эм	
- 49 кг	49 кг хүртэлх
- 53 кг	49 кг жингээс 53 кг жингийн хооронд
- 62 кг	53 кг жингээс 62 кг жингийн хооронд
-67 кг	62 кг жингээс 67 кг жингийн хооронд

- I. Тэмцээнийг Дэлхийн Таеквондогийн холбооны дүрмийн дагуу явуулна.
- II. Багийн тулаан нь “3-ын эсрэг 3” зарчмаар болон тамирчид ээлжлэн солигдох Tag-team хувилбарын холимоогоор явагдах болно.
- III. Баг тус бүр үндсэн 3 тамирчин, 1 сэлгээний тамирчинтай буюу нийт 4 тамирчинтай байна.
- IV. Тулаан энгийн хугун дээр явагдана.
- V. Баг тус бүр үндсэн 3 тамирчин болон 1 сэлгээний тамирчнаа дэвжээнд гарахын өмнө шүүгчийн бүрэлдэхүүнд мэдүүлж дугаар авна. Дэвжээнд тулалдах 3 тамирчин нь хамгийн бага жинтэй тамирчнаа 1 дугаараар дугаарлаж жингийн өсөх дарааллын дагуу хамгийн хүнд жинтэй тамирчин нь 3 дугаараар дугаарлагдана.
- VI. Багийн тулаанд өндөр онооны зөрүүгээр тулааны үндсэн үе дуусахаас өмнө ялалт шийдвэрлэгдэхгүй болно.
- VII. Тулаанууд 3 үеээр явагдана. (1 дүгээр үе 3 минут, 2 болон 3 дугаар үе тус бүр 3 минут) Үе хооронд 1 минут завсарлана.
- VIII. 1 дүгээр үе нь багийн тамирчин бүр 1 минут тулалдах уламжлалт хувилбараар явагдана. Энэ нь харгалзах дугаар бүхий тамирчинтайгаа тулалдана гэсэн үг юм.
- IX. 2 болон 3 дугаар үед багийн тамирчид дасгалжуулагчийн санал болгосноор ээлжлэн солигдох Tag-team хувилбараар 3 минут тулалдана. Tag-team хувилбарын 2 болон 3 дугаар үеүүдэд 1-ээс 3 дугаартай тамирчин бүр дор хаяж 1 удаа зайлшгүй дэвжээнд гарсан байх шаардлагатай.
- X. Баг бүрийн бүх тамирчид тойргийн тулаануудад оролцсон байх шаардлагатай.

3. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ

Жингийн тулаан: Тэмцээнд оролцогч нэг тамирчны дэвжээний төлбөр

- Улаанбаатар хотын тамирчид дэвжээний төлбөр 30000 (гучин мянга)-н төгрөг, Хөдөө орон нутгийн тамирчид
- УБ хотоос 1000 км дотогш 20000 (хорин мянга)-н төгрөг,
- УБ хотоос 1000км гадагш 10000 (арван мянга)-н төгрөг

Багийн тулаан: Тэмцээнд оролцогч нэг тамирчны дэвжээний төлбөр 20000 (хорин мянга)-н төгрөгийг зохион байгуулах хороонд тушааж мандатаа авна.

Оролцогчийн хураамж хүлээн авах данс:

Хаан банк: Хаан банк

Хүлээн авагч: Монголын Таеквондогийн холбоо

Дансны дугаар: 5431161905

4. ТЭМЦЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН ГАРГАХ

- Тэмцээнийг ДТХ-ны дүрмийн дагуу хасагдах системээр явуулж, 1-р байр нэг, 2-р байр нэг, 3-р байр хоёр тамирчин шалгаруулан шагнаж урамшуулна.
- Залуучууд, насанд хүрэгчид тус тус эрэгтэй эмэгтэй багаар байр эзлүүлнэ. Мастер ангилал болон багийн тулааны дүнг багийн дүнд тооцохгүй.

5. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- Жиндээ эхний 3 байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.
- Багийн дүнгээр 1, 2, 3-р байр эзэлсэн багуудыг цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулна.
- Багийн тулаанд 1, 2, 3-р байр эзэлсэн багуудыг медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.
- Мөн шилдэг эрэгтэй, эмэгтэй тамирчин, шүүгч, дасгалжуулагчдыг цом, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулна.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -